



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 10 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 10 дугаар хуралдааныг 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 10 дугаар хуралдаанаар “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн батлах тухай (Хорооны 2020 оны 71 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 4 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанд /2023-07-26/ хорооны Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газар /ЗЗҮТЗГ/, Радио давтамж зохицуулалт, хяналтын газар /РДЗХГ/, ажлын хэсгээс “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд өөрчлөлт оруулах тухай танилцуулга, уулзалт хэлэлцүүлэг болон албан тоотоор ирүүлсэн санал, эрх ашиг нь хөндөгдөж байгаа нэр бүхий 7 компанийн удирдлагатай ажлын хэсгийн хийсэн уулзалтын үр дүн, саналын товчооны танилцуулгыг сонсож, тус хуралдаанаас эрх ашиг нь хөндөгдөж байгаа ААН, хуулийн этгээд нартай уулзалт зохион байгуулах, Даргын зөвлөлийн хуралдаанд дахин хэлэлцүүлэх, баримт бичгийн төслийг Дараагийн Хорооны хуралдаанд хэлэлцүүлэх, батлуулах арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэгт даалгасан. Энэ асуудлыг 2023 ээлжит 09 дүгээр хуралдаанд /2023-08-09/ “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулга, тогтоолын төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах саналын төсөл, уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн, хэлэлцүүлгийн саналыг тусгасан саналын товчоо, хуулийн нөлөөллийн шинжилгээг зэрэг баримт бичгийг дахин хэлэлцүүлсэн билээ. Уг хуралдаанаас “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийн төсөл нь энэхүү баримт бичгийг шинэчлэн батлах төслийг боловсруулах, төслийг Даргын зөвлөлийн хуралдаанд дахин хэлэлцүүлэх, эрх ашиг нь хөндөгдөж байгаа үйлчилгээ эрхлэгч нартай уулзалт зохион байгуулах, шинэчилсэн баримт бичгийн төслийг албан тоотоор хүргүүлэх, улмаар Хорооны дараагийн хуралдаанд хэлэлцүүлэхийг ажлын хэсэг, ЗЗҮТЗГ /Д.Ариунболд/, РДЗХГ /З.Амгалан/-т тус тус чиглэл болгосон юм. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 08 дугаар, 09 дүгээр хуралдаанаас өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжүүлэх зорилгоор хорооны 2023 оны ээлжит 10 дугаар хуралдаанд ажлын хэсгээс “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн батлах тухай танилцуулга, шийдвэрийн төсөл, хавсралт баримт бичиг болох “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний шинэчилсэн төсөл, Даргын зөвлөлийн хуралдааны санал зөвлөмж, ирүүлсэн саналын товчооны нэгтгэл, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, нөлөөллийн шинжилгээ зэрэг баримт бичгийг хэлэлцээд, хуралдааны үеэр нэр бүхий зарим гишүүдээс гарсан саналыг тусган тогтоолыг батлахаар тогтов. Үүнд, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.10 дахь заалт болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/37 тоот тушаалын

хавсралтаар баталсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох журам”-ыг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 94 тоот “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн батлах тухай тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 71 тоот тогтоолыг хүчингүй болгов. Уг тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан шинээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын албан тоотоор хүргүүлээд байна.

Хорооны 2023 оны ээлжит 10 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 3 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 3 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 95 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 96 тоот тогтоолын хавсралтаар 6 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 97 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-08-18